| 210205                | Эрүүл мэндийн даатгал                            | 19,259,500.00         | 8,260,994.91   |
| 2103                  | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал        | 37,209,800.00         | 33,931,826.69  |
| 210301                | Гэрэл, цахилгаан                                 | 4,500,000.00          | 2,511,988.03   |
| 210302                | Түлш, халаалт                                    | 30,709,800.00         | 31,235,838.66  |
| 210303                | Цэвэр, бохир ус                                  | 2,000,000.00          | 184,000.00     |

|               |  |                  |                       |
|---------------|--|------------------|-----------------------|
| <b>2104</b>   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              |                  |                       |
| 210401        | Бичиг хэрэг  | 66,240,100.00    | 38,940,869.00         |
| 210402        | Тээвэр, шатахуун   | 10,833,600.00    | 4,467,740.00          |
| 210403        | Тээвэр, шатахуун   | 46,848,600.00    | 27,660,039.00         |
| 210403        | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 5,490,000.00     | 4,190,940.00          |
| 210405        | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 3,067,900.00     | 2,622,150.00          |
| <b>2105</b>   | <b>Нормативт зардал</b>  | 137,037,400.00   | 119,401,105.95        |
| 210501        | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 112,802,700.00   | 98,877,597.95         |
| 210502        | Хоол, хүнс   | 17,105,100.00    | 14,557,008.00         |
| 210503        | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 7,129,600.00     | 5,966,500.00          |
| <b>2106</b>   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 89,608,400.00    | 73,894,400.00         |
| 210601        | Багаж, техник, хэрэгсэл  | 61,358,400.00    | 61,351,400.00         |
| 210602        | Тавилга  | 4,000,000.00     | 4,000,000.00          |
| 210604        | Урсгал засвар  | 24,250,000.00    | 8,543,000.00          |
| <b>2107</b>   | <b>Томилолт, зочны зардал</b>  | 4,066,900.00     | 2,728,000.00          |
| 210702        | Дотоод албан томилолт  | 4,066,900.00     | 2,728,000.00          |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 24,400,800.00    | 6,001,800.00          |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,105,800.00    | 1,506,800.00          |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 5,295,000.00     | 4,495,000.00          |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 17,316,700.00    | 4,249,655.00          |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 17,316,700.00    | 4,249,655.00          |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 16,292,300.00    | 16,259,224.00         |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 16,292,300.00    | 16,259,224.00         |
| 213209        | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 16,292,300.00    | 16,259,224.00         |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 1,611,596,300.00 | 1,016,767,660.00      |
| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | 47,504,800.00    | 44,704,800.00         |
| 132001        | Орон нутгийн төсвөөс   | 47,504,800.00    | 44,704,800.00         |
| <b>1340</b>   | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                  | 1,466,039,400.00 | 969,804,100.00        |
| 134002        | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                            | 1,466,039,400.00 | 969,804,100.00        |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | 98,052,100.00    | 2,258,760.00          |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 98,052,100.00    | 2,258,760.00          |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              |                  | <b>18,698,902.77</b>  |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>             |                  | <b>212,202,480.39</b> |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлүүлэгчдэд ээлтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй үзүүлэх ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 10 зорилтыг дэвшүүлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89,187.2 мянган төгрөгөөр буюу 23 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт         |
|--|------------------|------------------|------------------|
| Б  | 1                | 2                | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                               | 18,698.9         | 212,202.5        | 193,503.6        |
| Авлага                                       | 63,402.1         | 1,00.5           | -62,401.6        |
| Бараа материал                               | 44,035.0         | 49,331.7         | 5,296.7          |
| Үндсэн хөрөнгө                               | 549,589.3        | 731,212.7        | 181,623.4        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>675,725.3</b> | <b>993,747.4</b> | <b>318,022.1</b> |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | <b>675,725.3</b> | <b>993,747.4</b> | <b>318,022.1</b> |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>675,725.3</b> | <b>993,747.4</b> | <b>318,022.1</b> |

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 193,503.6 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Авлагын данс 62,401.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсан нь нөлөөлсөн байна
- Үндсэн хөрөнгө данс 731,212.7 мянган төгрөг болж 181,623.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 65,995.0 мянга, хандиваар 6,590.0 мянга, үнэ төлбөргүй 130,658.6 мянга нийт 203,243.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 318,022.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг боловсруулдаг.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 1,555,945.4 мянга, орон нутгийн санхүүжилт 55,650.9 мянга нийт 1,611,596.3 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 818,381.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр харилцах дансны эхний үлдэгдэл 18,698.9 мянга, ЭМД-ийн сангаас 969,804.1 мянга, орон нутгийн санхүүжилт 44,704.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,474.0 мянга нийт 1,016,767.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 4,882.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 212,202.5 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 818,381.1 мянган төгрөг буюу 73.4 хувьтай зарцуулсан байна.

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д  | Хөтөлбөр, арга хэмжээ                       | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл | Зөрүү     | Биелэлт |
|------|---|-------------|-----------|-----------|---------|
| 1    | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 637,469.1   | 420,447.7 | 217,021.4 | 65.9%   |
| 2    | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж             | 828,570.3   | 268,238.3 | 560,332.0 | 32%     |
| 3    | 83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 89,906.0    | 89,873.3  | 32.7      | 100%    |
| 4    | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 51,155.9    | 35,326.8  | 15,829.1  | 69%     |
| 5    | 83201-Ангилалдаагүй бусад зардал            | 4,495.0     | 4,495.0   | -         | 100%    |
| НИЙТ |   | 1,611,596.3 | 818,381.1 | 39,070.4  | 50.8    |

Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 777,353.4 мянган төгрөг хэмнэгдсэн байна. Энэ нь боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн № 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 757,817.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,367.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 6,508.2 мянга, тээвэр шатахууны 7,590.0 зардал 14,098.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Дээрх зардлууд өсөхөд тээвэр шатахууны зардал өмнөх оноос 50 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.*

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий урсгал санхүүжилтийн 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14 шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

<sup>1</sup> Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |         | Биелэлт |         |      |
|-----------------|------------------------|---------|---------|---------|------|
|                 | Тоо                    | Дүн     | Тоо     | Дүн     | Хувь |
| Төлбөрийн акт   | 2                      | 2,360.0 | 2       | 2,360.0 | 100  |
| Албан шаардлага | 2                      | 2,900.0 | 2       | 2,900.0 | 100  |
| Зөвлөмж         | 1                      | -       | 1       | -       | 100  |
| Нийт дүн        | 5                      | 5,260.0 | 5       | 5,260.0 | 100  |

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,177.3 мянган төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс, 1,177.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны нэгдсэн сайтад мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Эмч ажилчдын 10, 11 сарын үр дүнгийн урамшууллыг олгохдоо 12 сард шинэчлэн тогтоосон цалингаас бодож 2,195.6 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 6.4.8 дахь /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь /Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ заалтыг тус тус зөрчсөн байна.

5.1.2 Өндөр насны тэтгэвэрт гарсан ахлах сувилагчид 4 сартай тэнцэх хэмжээний тэтгэмж 3,199.2 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх /Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй./ заалтыг зөрчсөн. иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

5.1.3 Хувь хүний орлогын албан татварт суутган тооцсон 2,725.9 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн.

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, болон иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

5.1.4 Хөдөлмөрийн чадвараа түр алдсан 3 иргэний цалингаас хүн амын орлогын албан татварыг 2,671.5 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар 22.1 /дараах орлогыг албан татвараас чөлөөлнө/ 22.1.2 дахь / хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого / болон иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1 Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий урсгал санхүүжилтийн 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

5.2.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр /орлогын төлөвлөгөө болон ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах/ гараагүй байхад эрүүл мэндийн төвийн ажилчдын цалинг 40 хувиар нэмэгдүүлж, төсвийг 12,456.4 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь /Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2 дугаар заалт /салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй/ -ыг тус тус зөрчсөн байна.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Албан томилолттой холбоотой**

Илрүүлэлт: Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.1 ДЭХ /Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно./, 2.5 дахь “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална.” заалттай нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Албан томилолтыг анхан шатны баримтыг бүрдүүлж, холбогдох журмын дагуу олгож байх.

### **2. Илүү цагийн хөлстэй холбоотой**

**Илрүүлэлт:** Эмч ажилчдад илүү цагийн хөлсийг олгохдоо зохих маягыг хөтлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.1 дэх / Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Илүү цагийн хөлсийг нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг үндэслэн олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                 | Үүнээс        |                |                 |                 |          |          |                                      |          |  |          |
|---|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|-----------------|----------|----------|--------------------------------------|----------|--|----------|
|   |             |                 | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |          | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн            | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      | Тоо                                  | Дүн      | Тоо  | Дүн      |
| Хувь хүний орлогын албан татварыг төсөвт дутуу төвлөрүүлсэн                                   | 1           | 1,777.0         | 1             | 1,177.0        |                 |                 |          |          |                                      |          |  |          |
| Эмч ажилчдад үр дүнгийн урамшууллыг буруу бодож олгосон                                       | 1           | 2,195.6         | 1             | 2,195.6        | -               | -               | -        | -        | -                                    | -        | -  | -        |
| Хөдөлмөрийн чадвараа түр алдсан 3 иргэний цалингаас хүн амын орлогын албан татварыг суутгасан | 1           | 2,725.9         | 1             | 2,725.9        |                 |                 |          |          |                                      |          |  |          |
| Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр ажилчдын цалинг нэмсэн.                         | 1           | 12,456.4        |               |                | 1               | 12,456.4        |          |          |                                      |          |  |          |
| Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон.    | 1           | -               | -             | -              | -               | -               | 1        | -        | -                                    | -        | -  | -        |
| Эмч ажилчдад илүү цагийн хөлсийг олгохдоо зохих маягыг хөтлөөгүй байна.                       | 1           |                 |               |                |                 |                 | 1        |          |                                      |          |  |          |
| <b>Дүн</b>  | <b>6</b>    | <b>21,880.8</b> | <b>3</b>      | <b>1,177.3</b> | <b>1</b>        | <b>12,456.4</b> | <b>2</b> | <b>-</b> | <b>-</b>                             | <b>-</b> | <b>-</b>                                       | <b>-</b> |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |                |                 |          |          |          |
|--|-------------|----------------|---------------|----------------|-----------------|----------|----------|----------|
|  |             |                | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |          | Зөвлөмж  |          |
|  | Дүн         | Тоо            | Дүн           | Тоо            | Дүн             | Тоо      | Дүн      | Тоо      |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил   |             |                |               |                |                 |          |          |          |
| Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий урсгал санхүүжилтийн 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14 шийдвэрийг мэдээлээгүй байна. | 1           | -              | -             | -              | 1               | -        | -        | -        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>-</b>       | <b>-</b>      | <b>-</b>       | <b>1</b>        | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил   |             |                |               |                |                 |          |          |          |
| Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд тэтгэмж давхардуулан олгосон   | 1           | 3,199.2        | 1             | 3,199.2        |                 |          | -        | -        |
|  |             |                |               |                |                 |          | -        |          |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>3,199.2</b> | <b>1</b>      | <b>3,199.2</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |
| <b>Нийт дүн</b>  | <b>2</b>    | <b>3,199.2</b> | <b>1</b>      | <b>3,199.2</b> | <b>1</b>        | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |